

Баян-Олгий аймгийн Олгий сумын барааны зах дээр 50 кг уут гурилын үнэ мянган тогроогоор буурч 43000 тогрогт, ямааны нэг кг ноолуурын үнэ мянган тогроогоор нэмэгдэж 34 мянган тогрогт хүрлээ.

Оноодрийн байдлаар кг хонины мах 4500, үхрийн мах 4000 тогрог байна. Литр сүүний үнэ 1500 тогрог байгаа боловч нэмэгдэх цаг нь ирж байна. Гадаадад мал, мах гаргана гэж байсан боловч шүлхий овчин илэрсэн нь саад болж магадгүй. Гэхдээ бэлчээрийн овс хомсдолтой, овлийн нохцол байдал хатуу болох шинжтэй болохоор малчид малных нь үнэ хямд ч гэсэн худалдаж борлуулах хандлагатай, овс тэжээлийн үнэ нэмэгдэх толовтэй байна. Бензин шатахууны үнэ ондор боловч тогтвортой. Орос, Казахстан улсууд болон хил залгаа районуудад нь руу очиж тээвэр хийдэг жолооч нар бензин хадгалдаг сав болон хэдэн канестраа хямдхан бензинээр дүүргэж ирээд ч ашигтай бизнес хийдэг болсон байна. Олгий суманд гаднаас хямдхан овс тэжээл, шингэн болон холдоосон сарлагийн сүү, тараг, аарц оруулж ирээд ашиг олох боломжтой байна.